

# **“ТЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 4-р сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

Хурал 2025 оны 4-р сарын 4-ний өдөр УБ хот, БГД, 25-р хорооны нутаг дэвсгэрт байрлах компанийн өөрийн байрны 3 давхарт байрлах хурлын танхимд 15.00 цагаас танхимаар болж өнгөрлөө. Хурлын ирцийн бүртгэлийг 2025 оны 2-р сарын 12-ны өдрийн ТУЗ-өөс томилогдсон тооллогын комисс явууллаа. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн нээж үг хэллээ.

**ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн:** Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа биечлэн оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж байна. Хурлын танхимд хувьцаа эзэмшигч нар цугларсан тул өнөөдрийн хурлын дэгийг танилцуулья. Үүнд:

| № | Хэлэлцэх асуудал                                                                  | Хугацаа  | Хэлэлцүүлэгч                  | Хурлын шийдвэр            |
|---|-----------------------------------------------------------------------------------|----------|-------------------------------|---------------------------|
| 1 | Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах                                          | 5 минут  | Хурал зохион байгуулах комисс | Хурлын тэмдэглэлд оруулах |
| 2 | Хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай                                               | 5 минут  | ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн     | Хурлын тэмдэглэлд оруулах |
| 3 | Хурлын тооллогын комиссын дүнг танилцуулах                                        | 5 минут  | Тооллогын комисс              | Тогтоолоор батлах         |
| 4 | Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан           | 10 минут | Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг | Хурлын тэмдэглэлд оруулах |
|   | Санал шүүмжлэл                                                                    | 5 минут  | Хувьцаа эзэмшигчид            |                           |
| 5 | Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт | 10 минут | Аудитын хорооны дарга Д.Туяа  | Тогтоолоор батлах         |
|   | Санал шүүмжлэл                                                                    | 10 минут | Хувьцаа эзэмшигчид            |                           |
| 6 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны зорилтын тухай                                 |          | Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг | Хурлын тэмдэглэлд оруулах |
|   | Санал шүүмжлэл                                                                    | 10 минут | Хувьцаа эзэмшигчид            |                           |
| 7 | Компанийн 2025 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай                                   |          | ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн     | Тогтоолоор батлах         |
|   | Санал шүүмжлэл                                                                    | 10 минут | Хувьцаа эзэмшигчид            |                           |

Дэгийн дагуу өнөөдрийн хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай мэдээллийг та бүхэнд танилцуулья. Манай “Компанийн дүрэм”-ийн 7.5-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга”-аар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга байна гэсэн заалт, мөн ТУЗ-ийн 2025 оны 02-р сарын 12-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай” 5 тоот тогтоолын дагуу хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Оюунсүрэн миний бие удирдан явуулна. Хурлын дэгийн дагуу хэлэлцэж буй асуудал бүр дээр хувьцаа эзэмшигчид та бүхэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд хурлын ирцийн талаарх мэдээллийг танилцуулна уу.

**Тооллогын комиссын дарга Г.Баасансүрэн:** Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Намайг Г.Баасансүрэн гэдэг. ТУЗ-ийн шийдвэрийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар томилогдон ажиллаж байна. Тооллогын комисс нь “Компанийн тухай хууль”-ийн 67.3.1-д заасны дагуу өнөөдрийн хурлын ирцийг танилцуулья. Өнөөдрийн хуралд биечлэн оролцож байгаа 23,725,299 саналын эрхтэй 17 хувьцаа эзэмшигчид, мөн хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,530,145 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч байна. Брокер дилерийн компаниудаас саналын хуудас ирүүлээгүй байна. 15 цаг 12 минутын байдлаар хурлын ирц 84,37 хувьтай байгаа бөгөөд тодорхой шалтгааны улмаас хуралдаа хоцорч ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцуулна гэдгийг мэдэгдэж байна.

“Компанийн тухай хууль”-ийн 69.1-р заалт, “Компанийн дүрэм”-ийн 7.4-р заалтанд заасны дагуу нийт саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж байна.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг бүртгэж байгаа тооллогын комисс хурлын ирцийн талаарх мэдээллийг танилцууллаа. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, тооллогын комиссын тогтоолын дагуу 84.37%-н хурлын ирцийг хангалттай гэж үзээд, хурал нээснийг мэдэгдэж байна. Энэхүү ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны зорилтын тухай
4. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай

**Хэлэлцсэн 1-р асуудал: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг**

Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг: Сайн байцгаана уу эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдээ, компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хуралдаа оролцож буй та бүхэндээ компанийн гүйцэтгэх удирдлагын өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулья. Хурлын материалд мөн хавсаргагдсан болно.

Манай компани нь өнгөрсөн 2024 онд 16 ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж, батлагдсан орлого, зарлагын төсөв төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Компанийн ажилтан ажиллагсадтай 2024 оны гэрээг шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аар улирал тутамд дүгнэж байна.
- ✓ Ажиллагсдын ээлжийн амралтын хуваарийг баталж, улмаар хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байна. Мөн ажилтан, ажиллагсад холбогдох хууль, журмын хүрээнд нөхөн олговор, ХЧТА-ны тэтгэмж зэргийг тухай бүр тооцон олгож байна.
- ✓ Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлуудыг өдөр тутамдаа тогтмол хийж гүйцэтгэлээ.
- ✓ Гүйцэтгэх удирдлагын баг нь 2024 онд нийт 209 түрээслэгчидтэй түрээсийн гэрээ байгуулсан бөгөөд тэдгээрийн бараа материалыг бүрэн даатгуулсан. Мөн 2024 оны түрээсийн гэрээний

гүйцэтгэлийн явцыг түрээслэгч бүртэй хамтран дүгнэж, улмаар 2025 оны 1, 2-р сарын түрээсийн төлбөрт

- 91-ээс дээш оноо авсан 122 түрээслэгчдэд 10%-ийн
  - 71-90 оноо авсан 82 түрээслэгчдэд 5%-ийн хөнгөлөлтийг олгосон.
  - 61-70 оноо авсан 5 түрээслэгчдэд хөнгөлөлт олгоогүй.
- ✓ Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Захидлаар худалдааны төвийн түрээслэгч, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудад галын аюултай нөхцөл байдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх, цахилгаан эрчим хүчийг хэрхэн хэмнэж ажиллах талаарх зөвлөгөө болон бусад мэдээллийг хүргүүлэн ажиллалаа. Мөн түрээслэгчдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг тухай бүр харилцан зөвшилцөх зарчмаар шийдвэрлэн хамтран ажиллалаа.
  - ✓ БГД-ийн Онцгой байдлын хэлтсээс 2024 оны галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг гаргуулан авсан.
  - ✓ Худалдааны төвд ашиглагдаж байгаа галын хорны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч гэмтсэн галын хорнуудыг шинэчлэн сольсон. Мөн ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн аваарийн гэрэл, гарц заасан тэмдэг тэмдэглэгээг шинэчилсэн. Түүнчлэн худалдааны төвийн лангуу, павильон түрээслэгчдийн ашиглаж байгаа галын хорны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч муудсан галын хорнуудыг шинэчлэн солиуллаа.
  - ✓ Худалдааны төвийн Б блокийн дотор талын гол хаалга болон 2 талын туслах хаалгыг шинээр хийлгэсэн.
  - ✓ Худалдааны төвийг цахилгаанаар хангадаг цахилгааны 10 000 квт-ын хос шугамд гэмтэл гарсныг “УБЦТС” ТӨХК-ийн Кабель засварын төвөөр засварлуулж, бэлэн байдлыг хангалаа. Мөн цахилгааны нөөц эх үүсвэр болох дизель станцад засвар хийлгэж, худалдааны төвийг хэвийн ажиллах боломжийг бүрдүүлэн ажилласан.
  - ✓ Худалдааны төвийн цэвэр, бохир усны тоолуурын баталгаат хугацаа дууссаныг шинэчлэн баталгаажууллаа.
  - ✓ Худалдааны төвийн гадна болон дотор талд өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, түрээслэгч, худалдан авагчдад цэвэр цэмцгэр, ая тухтай орчныг бүрдүүлэн ажилласан.
  - ✓ Худалдааны төвийн захиргаа сар бүрийн эхний долоо хоногийн баасан гаригийг “Их цэвэрлэгээний өдөр” болгон зарласан. Ингэснээр түрээслэгчид нь өөрсдийн лангуу павильондоо их цэвэрлэгээ хийж, улмаар худалдан борлуулж байгаа бараа материалаа эмх цэгцтэй хураан байршуулж худалдан авагчдад таатай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэн ажиллалаа.
  - ✓ “Хог хаягдлын тухай хууль”-ийн 10.2.10 дахь заалтын дагуу худалдааны төвийн эргэн тойрон дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас мөсийг тухай бүр цэвэрлэж, гадна талбайд байрлах хогийн функерийг ариутгаж, хог хаягдлаа 7 хоног бүр ачуулж заншлаа.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээллийг танилцуулж дууслаа. Асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул Гүйцэтгэх захирал тайлангаа үргэлжлүүлэв.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг танилцуулья. Үүнд:

- ✓ Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсдаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх

нийтийн эдэлбэр газрыг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж ажиллав.

- ✓ Худалдааны төвийн түрээслэгчид, тэдгээрийн худалдагч ажилтнуудад болон иргэдэд зориулан хэрэглээний усны зөв зохистой ашиглалт, цахилгаан эрчим хүчийг хэрхэн хэмнэж ажиллах талаарх таниулга сурталчилгааг тогтмол хийж байна.
- ✓ Худалдааны төвийн эргэн тойрон дахь ногоон байгууламжийг байнга тордож, иргэдээ эрүүл ая тухтай, цэвэр цэмцгэр орчинд таатай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.
- ✓ Худалдааны төвийн түрээслэгчдээс гарч байгаа бараа материалын сав баглаа боодол, ус ундааны хуванцар сав зэргийг ангилан ялгаж байна. Ингэснээр түрээслэгчдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг суулгаж байна.
- ✓ Компанийн оршин байгаа БГД-ийн үйлдвэр үйлчилгээний хэлтэс, 25-р хороо, хорооны цагдаатай байнгын холбоотой байж, тэдний санал хүсэлтийг дэмжиж, харилцан туслалцах зарчмаар хамтран ажиллаж ирлээ.

Компанийн санхүүгийн тайлангийн талаарх мэдээллийг танилцуулья.

- ✓ Худалдааны төвийн түрээслэгчдээс авах түрээсийн орлогыг тухайн сардаа багтаан бүрэн хурааж авч, түрээсийн төлбөрийн үлдэгдэлгүй ажиллалаа.
- ✓ Төрийн байгууллагуудад төлөх ёстой татвар хураамж, ашиглалтын болон бусад зардлуудыг цаг тухайд нь бүрэн төлсөн.
- ✓ Компанийн мөнгөн урсгалын тооцоог урьдчилан гаргаж, мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг тогтмол хийж, компанийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.
- ✓ Санхүүгийн тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох зохицуулагч байгууллагуудад тайлагнаж ирлээ.
- ✓ Компанийн 2024 оны санхүүгийн тайланд “Си Эс Ай” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2 удаагийн хөндлөнгийн аудитын ажлыг хийлгэсэн. Хурлын материалын 9-13-р хуудаст аудитын компанийн дүгнэлт хавсаргагдсан болно.

1. Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай :

- Компанийн нийт хөрөнгө 9.106,6 сая ₮ бөгөөд үүнээс:
  - ✓ Эргэлтийн хөрөнгө 3.279,4 сая ₮
  - ✓ Үндсэн хөрөнгө 3.448,7 сая ₮
  - ✓ Биет бус хөрөнгө 2.288,4 сая ₮

- Эзэмшигчийн өмч хөрөнгө 8.617,7 сая ₮

- Татварын дараах цэвэр ашиг 1.775,2 сая ₮ байна.

2. Орлогын үр дүнгийн тухай : Компани 2024 онд 2.577,5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 2.540,2 сая төгрөг байсантай харьцуулахад 102.3%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 37,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Хадгаламжийн хүүний орлогын төлөвлөгөө 420.0 сая төгрөг байсан бол гүйцэтгэл 450,8 сая төгрөг болж төлөвлөгөөг 30,8 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллалаа. Компанийн 2024 оны нийт орлогын төлөвлөгөө 2.960,2 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 3.028,3 сая төгрөг болж төлөвлөгөөг 68.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллав.

3. Зардлын тухай: Компани 2024 онд 1.253,1 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлын төлөвлөгөө 1.365,2 сая төгрөг байсантай харьцуулахад 91,2%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 112,1 сая төгрөгөөр хэмнэн ажиллалаа.


4. Ашгийн тухай: Татварын дараах цэвэр ашиг 1.775,2 сая төгрөг гарсан. 2024 оны ашгийн төлөвлөгөө 1.595,1 сая төгрөг байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 180,1 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.
5. Ногдол ашгийн тухай: 2024 онд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 22 төгрөг 60 мөнгө гарсан. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 20 төг 31 мөнгө байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 2 төг 29 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан.

Компанийн сүүлийн 5 жилийн санхүүгийн үзүүлэлтүүдийг дараах графикуудаар харуулав.

График 1



График 2



6. Төсөвт төвлөрүүлсэн татвар, шимтгэлийн тухай: Манай компани нь 2024 онд нийт 738,5 сая ₮-ийн татварыг улсад төлсөн байна. Үүнд:
  - ААН-ийн ОАТатварт 199,2 сая ₮
  - НДШимтгэлд сая төгрөг 91,7 сая ₮
  - ХХОАТатварт 44,3 сая ₮
  - НӨАТатварт 233,5 сая ₮
  - ҮХЭХАТатварт 56,6 сая ₮
  - Ногдол ашгийн татварт 101,4 сая ₮
  - Газрын төлбөрт 11,8 сая ₮

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын татварын албанд төлсөн татварын хэмжээг харуулав.

График 3



Хурлын материалын 9-13-р хуудаснуудад санхүүгийн аудитлагдсан тайлан хавсаргагдсан байгаа тул хувьцаа эзэмшигчид та бүхэн уншиж танилцана уу. Мөн өнөөдрийн хуралд манай компанийн санхүүгийн тайланд хөндлөнгийн шалгалт хийсэн аудитын компанийн аудитор Д.Чулуунбат оролцож байгааг дуулгахад таатай байна.

**“Си Эс Ай Аудит” ХХК-ийн аудитор Д.Чулуунбат:** Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Манай компани 2021 оноос эхлэн “Гермес Центр” ХК-ийн санхүүгийн тайланд жилдээ 2 удаа аудит хийж байна. Энэ компанийн хувьд санхүүгийн үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөвөөр тайлагнадаг. Мөн жилдээ 2 удаа ногдол ашиг тараадаг компани манай улсад миний мэдэхээр ганц хоёр энэ компани байдаг. Тэдний нэг нь энэ компани юм.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Аудитор Д.Чулуунбаттаа баярлалаа. Өнгөрсөн жилийн хуралд мөн оролцож байсныг та бүхэн санаж байгаа байхаа.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Аудитор Д.Чулуунбаттаа баярлалаа. Миний зүгээс санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээллийг танилцуулж дууслаа. Тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу.

**Хувьцаа эзэмшигч Г.Алтан-оч:** Хүүний мөнгө гэдэг нь юу билээ.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Гүйцэтгэх удирдлагын зүгээс сар бүр мөнгөн урсгалаа тооцдог. Үүний үндсэн дээр түрээслэгчдээс хураан авсан түрээсийн төлбөрийн илүүдэл мөнгийг арилжааны банкинд урт болон богино хугацаагаар хадгалуулж хүү олдог гэсэн үг.

**Хувьцаа эзэмшигч Б.Энх-Амгалан :** Мөнгөө хадгалуулсан тухайн банк дампуурвал яах вэ?

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Бидний зүгээс мөнгөн хөрөнгөө хадгалуулах банкныг сонгохдоо Монгол банкнаас арилжааны банкуудад тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан, мөн тухайн банкны тайлан баланс зэргийг харгалзан үзэж, эрсдэл багатай гэж үзсэн банкныг сонгож, мөнгөн хөрөнгөө хадгалуулдаг. Монголын томоохонд тооцогддог банкны нэгэнд нь хадгалуулж байна.

**Хувьцаа эзэмшигч Г.Алтан-оч:** Төрийн банкны 2 ажилтан танай ТУЗ-д байдаг юм байна.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** ТУЗ-д Төрийн банкны ажилтнууд байдаг боловч бид тухайн банкинд мөнгөн хөрөнгөө байршуулдаггүй.

**Хувьцаа эзэмшигч Г.Алтан-Оч :** Аан за ойлгомжтой.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Өөр асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг тайлангаа үргэлжлүүлэв.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Санхүүгийн тайлантай холбоотой асуух асуулт байхгүй гэсэн тул компанийн засаглалын талаарх тайлан мэдээллийг танилцуулья.

“Гермес Центр” ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, компанийн нийт ажилтан ажиллагсад, түрээслэгч, үйлчлүүлэгч зэрэг талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилго, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, чиглүүлэх, хянахад чиглэсэн бүтэц юм.

График 4



**Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлын талаар:** “Гермес Центр” ХК нь “Компанийн тухай хууль”, “Компанийн дүрэм”, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 5-ны өдөр тус компанийн оффисын 3-р давхрын хурлын танхимд явуулсан. Тухайн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хурлын материалтай урьдчилан танилцаж саналаа өгсөн 42,540,145 саналын эрхтэй 2 хувьцаа эзэмшигч, хуралд биечлэн оролцож саналаа өгсөн 25,260,012 саналын эрхтэй 13 хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн бөгөөд хурлын ирц 86.32%-тай байсан. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн Д.Оюунсүрэн, ердийн гишүүн Д.Алтанчимэг, ердийн гишүүн Н.Мөнхзул, ердийн гишүүн Б.Оюунцэцэг, ердийн гишүүн Б.Амарсанаа, мөн Аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Н.Батсайхан нар биечлэн оролцлоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан.
2. Компанийн 2024 оны ТУЗ-ийн төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан.
3. Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4-р сарын 05-ны өдрийн ээлжит хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг холбогдох материалуудын хамт СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн.

**Компанийн засаглалын үйл ажиллагааны талаар:** “Гермес Центр” ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.

1. Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлуудыг (2024.02.14, 2024.05.29, 2024.08.30, 2024.12.10) холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг СЗХ болон МХБиржид хүргүүлсэн.
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлуудыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан санал, зөвлөмжийг ТУЗ-ийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд оруулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан.
3. Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2023 оны сүүлийн хагас жил, 2024 оны эхний хагас жилийн ногдол ашгийн мөнгийг компанийн төв байр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдэд бүрэн тараасан.
4. СЗХорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу компанийн 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг холбогдох маягтын дагуу бэлтгэж СЗХ болох МХБ-д тус тус хүргүүлэн ажиллалаа. Мөн МХБ-ийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудас, өөрийн компанийн [www.hermescenter.mn](http://www.hermescenter.mn) цахим хуудсанд тус тус нийтэлж олон нийтэд мэдээлсэн.
5. СЗХорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг холбогдох маягтын дагуу өөрийн компанийн засаглалыг үнэлж СЗХ, МХБ-д хүргүүлсэн.
6. Компанийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн дунд хийсэн судалгааг ТУЗ-ийн хуралд танилцуулж ажилласан.
7. Бүртгэлтэй брокер дилерийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн гадаад дотоодын хувьцаа эзэмшигчдийг гүйцэтгэх захирал хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг өгч ажилласан.
8. СЗХ болон МХБиржээс баталсан заавар журмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
9. Компанийн вэб сайт, мэдээллийн самбарны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, түрээслэгчдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж ирлээ.

**Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн талаар:** Монголын хөрөнгийн биржийн “Компанийн засаглалын кодексийг үнэлэх үнэлгээ”-ний аргачлалын дагуу 2024 оны 6-р сарын 27-ны өдрийн байдлаарх “Гермес Центр” ХК-ийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан

Хүснэгт 1

| № | Гарчиг                              | Авбал<br>зохих<br>нийт оноо | 2024. 06. 27-ны өдрийн<br>байдлаар өөрийн |       | 2024. 06. 27-ны өдрийн<br>байдлаар СЗХорооны |        |
|---|-------------------------------------|-----------------------------|-------------------------------------------|-------|----------------------------------------------|--------|
|   |                                     |                             | Үнэлсэн                                   | Хувь  | Хяналтын<br>оноо                             | Хувь   |
| 1 | ТУЗ-ийн бүтэц, зохион<br>байгуулалт | 12                          | 9                                         | 75.0% | 8                                            | 66.70% |

|             |                                               |    |    |        |    |         |
|-------------|-----------------------------------------------|----|----|--------|----|---------|
| 2           | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10 | 8  | 80.0%  | 7  | 70.0%   |
| 3           | Тайлагнал, мэдээллийн илтөд, байдал           | 6  | 6  | 100.0% | 6  | 100.00% |
| 4           | Аудит, хяналтын тогтолцоо                     | 6  | 6  | 100.0% | 4  | 66.70%  |
| 5           | Эрсдэлийн удирдлага                           | 8  | 7  | 87.5%  | 7  | 87.50%  |
| 6           | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал    | 6  | 6  | 100.0% | 4  | 66.70%  |
| 7           | Оролцогч талуудын эрх ашиг                    | 8  | 7  | 87.5%  | 7  | 87.50%  |
| 8           | Компанийн соёл                                | 6  | 6  | 100.0% | 6  | 100.0%  |
| 9           | Хувьцаа эзэмшигчдийн эрх                      | 10 | 10 | 100.0% | 10 | 100.0%  |
| Нэгдсэн дүн |                                               | 72 | 65 | 92.3%  | 59 | 82.9%   |

СЗХорооны хяналтын үнэлгээгээр манай компани 59 оноо авч улмаар дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй гэж үнэлэгдсэн. Компанийн ТУЗ нь СЗХорооны үнэлгээний дүнг үндэслэн дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:

1. Компанийн хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг шинээр баталсан.
2. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан.
3. Компанийн ТУЗ, түүний дэргэдэх хороод, дарга, гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинээр баталсан.
4. Компанийн ажилтан, ажиллагсдын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журмыг шинээр баталсан.
5. Компанийн ажилтан ажиллагсдын ажлын байранд мөрдөж ажиллах хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан.
6. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг шинэчлэн томилсон.
7. Компанийн ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын төлөвлөгөөг баталсан.

**Компанийн хувьцаа эзэмшигчдийн талаар:** Компанийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр буюу 2024 оны 09-р сарын 18-ны өдрөөр нийт 1067 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хүснэгт 2

| №    | Хувьцаа эзэмшигчдийн бүтэц | Хувьцаа эзэмшигчдийн иргэншил | Хувьцаа эзэмшигчдийн тоо | Эзэмшиж буй хувьцааны |                           |
|------|----------------------------|-------------------------------|--------------------------|-----------------------|---------------------------|
|      |                            |                               |                          | Тоо ширхэг            | Нийт хувьцаанд эзлэх хувь |
| 1    | Байгууллага                | Гадаад                        | 3                        | 4,983,603             | 6.3                       |
| 2    |                            | Дотоод                        | 21                       | 758,026               | 1                         |
| 3    | Иргэн                      | Гадаад                        | 24                       | 2,189,659             | 2.8                       |
| 4    |                            | Дотоод                        | 1019                     | 70,611,713            | 90                        |
| Нийт |                            |                               | 1067                     | 78,543,001            | 100                       |

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 3

| №                  | Хувьцаа эзэмшигчийн нэр       | Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг | Нийт хувьцаанд эзлэх хувь |
|--------------------|-------------------------------|----------------------------------|---------------------------|
| 1                  | Иргэн Д.Зоригт                | 42,530,145                       | 54.15%                    |
| 2                  | Иргэн Д.Оюунсүрэн             | 23,460,015                       | 29.87%                    |
| 3                  | "Импера монголиа холдинг" ХХК | 4,915,165                        | 6.26%                     |
| 4                  | Бусад                         | 7,637,676                        | 9.72%                     |
| Нийт хувьцааны тоо |                               | 78,543,001                       | 100%                      |

Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, эзэмшлийн хувь хэмжээний талаар:

Хүснэгт 4

| №    | Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр | Эрхэлж буй ажил,                                                                 | Эзэмшиж буй хувьцааны |                |
|------|----------------------------------------|----------------------------------------------------------------------------------|-----------------------|----------------|
|      |                                        |                                                                                  | Тоо ширхэг            | Эзэмшлийн хувь |
| 1    | Дашзэвэг овогтой Зоригт                | Иргэн                                                                            | 42,530,145            | 54.15          |
| 2    | Дугаржав овогтой Оюунсүрэн             | "Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль" ХХК-ийн гүйцэтгэх захирал | 23,460,015            | 29.87          |
| Нийт |                                        |                                                                                  | 65,990,160            | 84.02          |

Манай компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь гэр бүлийн гишүүд байдаг бөгөөд одоогоор өөрчлөлт ороогүй байна.

**Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаар:** Манай компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага байдаг. ТУЗ-ийн гишүүдийг компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас "Компанийн дүрэм"-ийн 7.23-р заалтын дагуу 5 жилийн хугацаатай улируулан сонгосон.

| ТУЗ-ийн Ердийн гишүүд         |                                                                                     |                                                                                     |                                                                                     |                                                                                     |                                                                                     |                                                                                      | ТУЗ-ийн Хараат бус гишүүд                                                             |                                                                                       |                                                                                       |
|-------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|
| Зурал                         |  |  |  |  |  |  |  |  |  |
| Овог нэр                      | Д.Оюунсүрэн                                                                         | Б.Оюунсүрэн                                                                         | Б.Амарсанаа                                                                         | Д.Алтанмуг                                                                          | Н.Мөнхзул                                                                           | Ц.Түвшинжаргал                                                                       | Д.Тува                                                                                | Н.Батсайхан                                                                           | Б.Алтанмуг                                                                            |
| Мэргэжил                      | Инженер, эдийн засагч                                                               | Инженер, эдийн засагч                                                               | Эрх зүйч                                                                            | Нягтлан бодогч                                                                      | Эдийн засагч                                                                        | Зураач                                                                               | Эдийн засагч                                                                          | Эдийн засагч                                                                          | Банкны эдийн засагч                                                                   |
| Эрхэлж буй ажил, албан тушаал | "ASU" сургуулийн гүйцэтгэх захирал                                                  | "Термес Центр" ХК-ийн гүйцэтгэх захирал                                             | "Төрийн банк" ХК-ийн дэд захирал                                                    | "Одол" ХХК-ийн нягтлан бодогч                                                       | Хувьцаа хөдөлмөр эрхэлдэг                                                           | Хувьцаа хөдөлмөр эрхэлдэг                                                            | "Төрийн банк" ХК-ийн хэлтсийн захирал                                                 | "Монгол Даатгал" ХК-ийн салбарын захирал                                              | "Ундрах дөл" ХХК-ийн гүйцэтгэх захирал                                                |
| Хувьцааны тоо                 | 23,460,015                                                                          | 85,741                                                                              | Хувьцаа эзэмшдэггүй                                                                 | 1,207,710                                                                           | Хувьцаа эзэмшдэггүй                                                                 | 50,000                                                                               | Хувьцаа эзэмшдэггүй                                                                   | Хувьцаа эзэмшдэггүй                                                                   | Хувьцаа эзэмшдэггүй                                                                   |
| Хурлын ирц %                  | 100                                                                                 | 100                                                                                 | 100                                                                                 | 75                                                                                  | 100                                                                                 | 100                                                                                  | 100                                                                                   | 100                                                                                   | 100                                                                                   |

Компанийн ТУЗ-ийн 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн хурлаар “Компанийн засаглалын кодекс”-т нийцүүлэн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр томилох асуудлыг хэлэлцэж, улмаар хороодын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН**

**Эрсдэл аудитын хорооны бүрэлдэхүүн**

|        |             |                           |
|--------|-------------|---------------------------|
| Дарга  | Д.Туяа      | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүн | Н.Батсайхан | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүн | Н.Мөнхзул   | ТУЗ-ийн ердийн гишүүн     |

**Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн**

|        |              |                           |
|--------|--------------|---------------------------|
| Дарга  | Б.Алтангэрэл | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүн | Д.Оюунсүрэн  | ТУЗ-ийн ердийн гишүүн     |
| Гишүүн | Д.Туяа       | ТУЗ-ийн хараат бус гишүүн |

**Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн**

|        |              |                           |
|--------|--------------|---------------------------|
| Дарга  | Н.Батсайхан  | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүн | Б.Алтангэрэл | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| Гишүүн | Б.Оюунцэцэг  | ТУЗ-ийн ердийн гишүүн     |

Өнөөдрийн хуралд манай ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Туяа, хараат бус гишүүн Б.Алтангэрэл, ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн, ердийн гишүүн Б.Оюунцэцэг миний бие, Б.Амарсанаа, Ц.Түвшинжаргал нар биечлэн оролцож байна.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Энэ дашрамд хуралдаа хүрэлцэн ирсэн ТУЗ-ийн гишүүдээ талархал илэрхийлье. Ингээд гүйцэтгэх захирлын тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу. Байхгүй бол тайлангаа үргэлжлүүлэх үү.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул гүйцэтгэх захирал тайлангаа үргэлжлүүлэв.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Асуух асуулт байхгүй гэсэн тул ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой тайланг танилцуулья. Манай компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, компанийн үйл ажиллагааг зөв зохистой төвшинд хүргэх, компанийн зорилго, зорилтоо биелүүлэхэд Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай чиглэлийг өгч ажиллаж ирсэн. Компанийн ТУЗ нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа танхимаар 4 удаа хуралдаж, нийт 37 асуудлыг хэлэлцэн 21 тогтоол шийдвэрийг гаргаж, тэдгээрийн биелэлтэнд хяналт тавин ажилласан.


ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд 2 удаа танхимаар хуралдаж 2 санал, Цалин урамшууллын хороо нь 2 удаа хуралдаж 2 саналыг тус тус гарган ажиллалаа. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багийн бүтцэд өөрчлөлт ороогүй тул компанийн Нэр дэвшүүлэх хороо өнгөрсөн онд хуралдаагүй болно.

**Компанийн хувьцааны үнэ ханш, ногдол ашгийн талаарх мэдээллийг танилцуулья.** Манай компанийн хувьцаа 2024 онд Монголын хөрөнгийн бирж дээр 147 өдөр идэвхитэй арилжаалагдаж нийт 456,573 ширхэг буюу 81.7 сая төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна. Арилжааны дүнг өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан бөгөөд энэ нь хувьцааны үнэ ханш өсөж, улмаар жилд 2 удаа

ногдол ашиг олгож байгаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн зүгээс хувьцаагаа арилжаалах сонирхолгүй болсон болов уу гэж дүгнэж байна.

Сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны тоон үзүүлэлтийг графикаар харуулав.

График 6



Манай компани нь Монголын Хөрөнгийн Биржийн 2 дугаар ангилалд багтдаг. 2024 оны сүүлийн арилжааны өдөр буюу 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар компанийн нэгж хувьцааны хаалтын ханш 205.7 төгрөг байсан бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 16.1 тэрбум төгрөг болсон байсан.

График 7



**Ногдол ашгийн тухай:** "Термес центр" ХК нь 2014 оноос эхлэн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашигт нийцүүлэн жилд 2 удаа ногдол ашиг хуваарилж ирсэн. Дараах хүснэгтээр компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд нэгж хувьцаанд оногдсон ногдол ашгийн мэдээллийг харуулав.

Хүснэгт 5

| Ногдол ашиг хуваарилсан огноо  |                   | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг) | Нийт зарласан ногдол ашгийн дүн (сая төг) | Хувьцаа эзэмшигчдийн тоо | Ногдол ашиг олгосон хэлбэр         |                 | Ногдол ашиг тараалтын хувь |
|--------------------------------|-------------------|-------------------------------------------|-------------------------------------------|--------------------------|------------------------------------|-----------------|----------------------------|
|                                |                   |                                           |                                           |                          | ҮЦТХТөвөөр зуучлуулан бэлэн бусаар | Компани дээрээс |                            |
| 2022                           | Эхний хагас жил   | 8.02                                      | 629.9                                     | 1024                     | 90.2                               | 539.7           | 100%                       |
|                                | Сүүлийн хагас жил | 7.50                                      | 589.1                                     | 1051                     | 84.4                               | 504.7           | 100%                       |
|                                | Нийт              | 15.52                                     | 1219                                      |                          |                                    |                 |                            |
| 2023                           | Эхний хагас жил   | 12.00                                     | 942.5                                     | 1056                     | 135.0                              | 807.5           | 100%                       |
|                                | Сүүлийн хагас жил | 9.20                                      | 722.6                                     | 1065                     | 103.5                              | 619.1           | 100%                       |
|                                | Нийт              | 21.20                                     | 1665.1                                    |                          |                                    |                 |                            |
| 2024                           | Эхний хагас жил   | 12.50                                     | 981.8                                     | 1067                     | 140.6                              | 841.2           | 100%                       |
|                                | Сүүлийн хагас жил | 9.60                                      | 754.0                                     | 1076                     | 108.0                              | 646.0           | 100%                       |
|                                | Нийт              | 22.10                                     | 1735.8                                    |                          |                                    |                 |                            |
| ХХОАТатвар хасаагүй дүн болно. |                   |                                           |                                           |                          |                                    |                 |                            |

Сүүлийн 5 жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэд тараасан болон нэгж хувьцаанд тараасан ногдол ашгийн мэдээллийг харуулав.

График 8



График 9



Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь тухайн жилүүдэд хуваарилсан ногдол ашгийг компанийн төв байр болон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 100% тарааж, ногдол ашиг тараалтын тайланг “Компанийн тухай хууль”-ийн 46.14, 46.15 дахь заалтын дагуу ХЭХуралд тайлагнаж, улмаар Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.

**Компанийн 2025 оны ногдол ашгийн талаар:** “Термес Центр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, санхүүгийн тайланд жилд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр 2 удаа хуваарилах саналтай байгааг хувьцаа эзэмшигчдэдээ дуулгахад таатай байна. Ингээд гүйцэтгэх захирлын зүгээс тайлангаа танилцуулж дууслаа. Асууж тодруулах зүйл байвал чөлөөтэй асууна уу.

**Хувьцаа эзэмшигч Б.Энх-Амгалан:** Худалдааны төвийг ажиллуулахаас гадна өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө байгаа юу.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Тайлангаа дэлгэрэнгүй танилцуулсан Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэгтээ баярлалаа. Мөн тайланд анхаарлаа хандуулсан хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье. Ингээд таны асуусан асуултанд хариулья. Манай компани нь одоогоор барилгын материалын худалдаа эрхлэгч жижиг дунд бизнес эрхлэгчдэд түрээсийн талбай түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд үйл ажиллагаагаа өргөтгөх бодлого байхгүй байгааг та бүхэнд дуулгая. Энэ асуудлыг бид жил бүр л танилцуулдаг. Манай компанийн зорилго бол тогтвортой үйл ажиллагаа явуулах, мөн эдгээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

**Хувьцаа эзэмшигч Б.Энх-Амгалан:** Цаашид хувьцааны үнэ ханш болон ногдол ашгийг нэмэгдүүлэхийн тулд ямар бодлого баримталж ажиллах вэ. Анх хувьцаа гаргахдаа 100 төгрөг байсан одоо дөнгөж л 200 гаруй төгрөг болсон байна.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Сая ТУЗ-ийн дарга та бүхэнд компанийн зорилго бол тогтвортой байх гэдгийг танилцуулсан. Манай компанийн хувьд түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түрээсийн төлбөрийг нэмэгдүүлж байж л ногдол ашгийг нэмэгдүүлэх боломжтой. Ингэсэн тохиолдолд эцсийн хэрэглэгч болох худалдан авагчдад ачаалал ирнэ гэж харж байгаа. Тиймээс

түрээсийн үнэ тарифын тогтвортой бодлого баримталж байгаа. Та бүхэнд дараах хүснэгтээр сүүлийн 5 жилийн хугацаанд мөрдөж ажилласан түрээсийн үнэ тарифын талаарх судалгааг танилцуулья.

| №                  | Үзүүлэлт      | 2021 он | 2022 он | 2023 он   | 2024 он   | 2025 он   |
|--------------------|---------------|---------|---------|-----------|-----------|-----------|
| <b>Талбайн үнэ</b> |               |         |         |           |           |           |
| 1                  | Павильон      | 20,000  | 24,000  | 30,000    | 30,000    | 36,000    |
| 2                  | Лангуу        | 200,000 | 250,000 | 312,500   | 312,500   | 375,000   |
| 3                  | Үзүүлэн том   | 800,000 | 960,000 | 1,200,000 | 1,200,000 | 1,440,000 |
| 4                  | Үзүүлэн жижиг | 500,000 | 600,000 | 750,000   | 750,000   | 900,000   |
| 5                  | Контейнер     | 150,000 | 150,000 | 150,000   | 150,000   | 150,000   |
| 6                  | Интернэт      | 35,000  | 35,000  | 35,000    | 35,000    | 35,000    |

Дээрх хүснэгтээс харахад манай худалдааны төвийн түрээсийн талбайн үнэ тарифыг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг худалдааны төвүүдтэй харьцуулбал дундаж байгаа. Манай худалдааны төвийн түрээсийн үнэ тарифыг жил бүр ТУЗ-өөс баталж өгдөг. Компанийн ирээдүйн зорилго нь хэт ашгийн төлөө бус бөгөөд хувьцаа эзэмшигч, түрээслэгч, ажилтан ажиллагсад, худалдан авагч гэсэн 4 оролцогч талуудын эрх ашгийг энэ тэнцүү хангахыг зорин ажиллаж байгаа. Мөн нийт хувьцааны 84 гаруй хувийг нэг гэр бүлийн гишүүд, мөн 6 гаруй хувийг нэг компани, үлдсэн 9.2 хувь нь буюу маш бага хувийг олон нийт болох 1073 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Эдгээр хүмүүсийн зүгээс хувьцаагаа арилжаалах сонирхол бага бол хувьцааны үнэ ханш зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулиараа зохицуулагдана гэж дүгнэж байна.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Би жил жилийн хуралд энэ тухайгаа хэлж байсан. Энэ компанийн 84 гаруй хувийг гэр бүлийн хүн болох Д.Зоригтын хамтаар эзэмшиж байна. Бидний зүгээс хувьцаа гаргаснаас хойш нэг ч хувьцаа нэмээгүй мөн зараагүй бөгөөд цаашид ч хувьцааны тоогоо нэмэгдүүлэх болон зарах сонирхол байхгүй байгаа гэдгийг дахин хэлье. Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул хурлын дэгийн дагуу 2-р асуудлыг Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа танилцуулна уу.

*Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан тэмдэглэв.*

**Хэлэлцэх 2-р асуудал:** Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах тухай – хэлэлцүүлэгч Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа

**Эрсдэл аудитын хорооны дарга Д.Туяа:** Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие нь тус компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Эрсдэл аудитын хорооны даргаар ажилладаг.

ТУЗ-өөс компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд өгсөн дүгнэлтийг та бүхэнд сонордуулья.

“Термес Центр” ХКомпанийн 2024 оны татварын дараах цэвэр ашиг 1.775,2 сая төгрөг байгаа бөгөөд энэхүү ашгийг төлөвлөгөө 1,595.1 сая төгрөг байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 180.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Компанийн 2024 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 22 төгрөг 60 мөнгө байгаа бөгөөд ногдол ашгийн төлөвлөгөө 20 төг 31 мөнгө байсантай харьцуулахад 111%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 2 төг 29 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан байна.

Тиймээс гүйцэтгэх удирдлагын багийг 2024 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай сайн ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэсэн болно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн ТУЗ-ийн дүгнэлт болон аудиттай холбоотой асуух асуулт байвал асууна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй гэсэн тул дэгийн дагуу хурлаа үргэлжлүүлэв.

*Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрч, тогтоолоор батлав.*

*Хэлэлцсэн 3-р асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны зорилт – Хэлэлцүүлэгч гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:*

*Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:* Хурлын дэгийн дагуу миний бие компанийн 2025 оны зорилтыг товч танилцуулья. Манай компани нь 2025 онд бүтэц зохион байгуулалтын хувьд 16 ажилтан ажиллагсадтай, 3,559.9 сая төгрөгийн орлоготой, 1,427.6 сая төгрөгийн зардалтай, 1,919.1 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай, нэгж хувьцаанд 24 төгрөг 43 мөнгөний ногдол ашигтай ажиллахаар төлөвлөж, ТУЗ-ийн хурлаараа хэлэлцүүлэн батлуулсан. Та бүхэнд 2025 оны зорилттой холбоотой асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг сайшаан тэмдэглэв.

*Хэлэлцсэн 3-р асуудлаар гаргасан шийдвэр: Компанийн 2025 оны зорилтыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжиж, хурлын тэмдэглэлд оруулав.*

*Хэлэлцсэн 4-р асуудал: Компанийн ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай – хэлэлцүүлэгч хурлын дарга Д.Оюунсүрэн:*

*Хурлын дарга Д.Оюунсүрэн:* Хурлын дэгийн дагуу компанийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийн гүйцэтгэл болон 2025 оны төсвийн тухай танилцуулья.

*ТУЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэл:* Тус компани нь 2024 онд ТУЗ-ийн цалинд 25.9 сая төгрөгийн зардлыг гаргаж олгож ажилласан.

*ТУЗ-ийн 2025 оны төсвийн тухай:* Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 3 тоот тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн 792,000.00 төгрөг байхаар шинэчилсэн байна.

Тиймээс “Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалинг дараах байдлаар шинэчлэн тогтоох саналыг оруулж байна.

| №          | Албан тушаал                 | Орон тоо | Нэг удаагийн хурлын цалин |              | Хурлын тоо | Нийт 2025 оны жилийн цалин |
|------------|------------------------------|----------|---------------------------|--------------|------------|----------------------------|
|            |                              |          | 2024 он                   | 2025 он      |            |                            |
| 1          | ТУЗ-ийн дарга                | 1        | 720,000.00                | 864,000.00   | 4          | 3,456,000.00               |
| 2          | ТУЗ-ийн гишүүд               | 8        | 660,000.00                | 792,000.00   | 4          | 25,344,000.00              |
| 3          | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 1        | 660,000.00                | 1,000,000.00 | 4          | 4,000,000.00               |
| Нийт төсөв |                              | 10       |                           |              |            | 32,800,000.00              |

Жич: ТУЗ-ийн дарга, гишүүд нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн цалинг олгох бөгөөд жилд 4 удаа буюу улирал тутам хуралдахаар тогтсон. Хуралд ТУЗ-ийн гишүүн ямар нэгэн шалтгаанаар оролцоогүй тохиолдолд цалин олгогдохгүй. Хувьцаа эзэмшигчид та бүхэн саналаа хэлнэ үү.

**Хувьцаа эзэмшигч С.Уранчимэг:** Эрдэнэт хотод нэг салбар худалдааны төв ажиллуулж байсан. Тэр юу болсон вэ

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Эрдэнэт хот дахь салбар худалдааны төв нь анхнаасаа алдагдалтай ажиллаж байсан учраас 2014 онд зарж борлуулсан. Тухайн худалдааны төвийг борлуулсан мөнгөн хөрөнгө нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө учраас шууд ногдол ашиг болгон хуваарилж болохгүй. Тиймээс сар бүр түрээслэгчдээс хураан авч буй түрээсийн төлбөрийн илүүдэл мөнгөтэй нийлүүлж урт болон богино хугацаат хадгаламж хэлбэрээр банкинд хадгалуулж байна. Үр дүнд нь өнгөрсөн 2024 онд гэхэд 450.7 сая төгрөгийн хүүний орлого олсон.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Эрдэнэт хотод байсан салбарын орлого нь зардлаа төлж дийлэхгүй, улмаар эндээс мөнгө байнга татах болсон тул худалдан борлуулах шийдвэрийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн юм. Өөр асуух асуулт байна уу.

**Хувьцаа эзэмшигч Б.Энх-Амгалан:** Танай худалдааны төвийн хажуу талд мөн ижил үйл ажиллагаа эрхэлдэг худалдааны төв байгуулагдсан байна. Танай түрээслэгчдээс энэ худалдааны төв рүү гэрээгээ цуцалж шилжсэн түрээслэгч байгаа юу. Өрсөлдөгчдийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.

**Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг:** Манай худалдааны төвийн түрээслэгчдээс цөөн тооны түрээслэгчид талбайгаа томруулах, салбар нээх зорилгоор тэднийд талбай түрээсэлсэн. Одоогоор манай түрээслэгчдээс нэг ч түрээслэгч гэрээгээ цуцалж гараагүй байна. Бидний зүгээс тухайн худалдааны төвийн үнэ ханшийн талаар судалгаа хийхэд манай худалдааны төвийн 1м2 талбайн түрээсийн төлбөрөөс 1,000 төгрөгөөр бага буюу 35,000 төгрөгөөр түрээсэлж байна. Аливаа худалдааны төвүүдийн үйл ажиллагаа дор хаяж 3 жилийн дараанаас л тогтворжиж эхэлдэг.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Өөр асуух асуулт байна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлэв.

**Хэлэлцсэн 4-р асуудлаар гаргасан шийдвэр:** Компанийн ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% сайшаан дэмжиж тогтоолоор батлав.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй бол тооллогын комисс саналын хуудсыг хураан авч нэгтгээд, санал хураалтын нэгдсэн дүнг танилцуулна уу.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт байхгүй, хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж, тооллогын комисст саналын хуудаснуудаа хураалгав.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хураан авч нэгтгэн тоолоод, санал хураалтын нэгдсэн дүнг хурал зохион байгуулах комисст хүлээлгэн өгөв.

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дарга Г.Баасансүрэн:** Өнөөдрийн хуралд нийт 67,469,654 саналын эрхтэй 20 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгсөн байна. Брокер дилерийн компаниудаас саналын хуудас ирүүлээгүй. Мөн хүчингүй болсон саналын хуудас байхгүй.

Саналын хуудасны нэгдсэн дүнг танилцуулья. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав.
2. Компанийн ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн тул тогтоолын төслийг батлав.

**Хурлын дарга Д.Оюунсүрэн:** Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт, санал хүсэлт байхгүй бол хурлын дэгийн дагуу өнөөдрийн хурлыг өндөрлөснийг мэдэгдэж байна. Энэ удаагийн хурлаар хэлэлцсэн асуудлын тогтоолын төслүүд саналын хуудасны дүнгээр баталгаажиг байна. Бидний ажлыг ойлгож, хүндэтгэн хуралдаа идэвхитэй оролцдог хувьцаа эзэмшигчдэдээ гүнээ талархал илэрхийлье. Баярлалаа баяртай. Дараа жилийн ээлжит хурлаар дахин баяртай уулзацгаая.

“Гермес центр”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 1 цаг үргэлжилж, 16 цаг 15 минутанд дуусав. Хурал амжилттай болж өнгөрлөө.



Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга Д.Оюунсүрэн

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэсүрэн